

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/48 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын аудиторов албан тушаалын сонгон шалгаруулалтыг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс зарлаж байна.

1. Сонгон шалгаруулалтад оролцох иргэн нь Төрийн албаны тухай хуулийн 10.1-д заасан ерөнхий шаардлага болон томилох эрх бүхий этгээдийн баталсан ажлын байранд тавигдах дараах шаардлагыг хангасан байна.

Тухайн ажлын байранд тавигдах шаардлага:

Гүйцэтгэлийн аудитын газрын аудитор:

1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1. Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Дээд боловсролын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх	
		Мэргэжил	Нийгмийн салбарын чиглэлээр болон санхүү	
		Мэргэшил	Эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл, ажиллах хүч, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, болон эдгээртэй адилтгах бусад чиглэлээр мэргэжил эзэмшсэн	
		Туршлага	Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх	
			-Хууль зүйн зохих мэдлэгтэй байх; -Монгол хэл бичгийн болон албан хэрэг хөтлөлтийн ур чадвар эзэмшсэн байх; -Баримт бичиг, шийдвэрийн төсөл	

		боловсруулах ажилд мэргэшсэн; -Компьютерийн өргөн хэрэглээний программыг бүрэн эзэмшсэн байх; -Удирдан зохион байгуулах чадвартай байх; -Судалгааны туршлагатай байх;	
	1.2. Тусгай шаардлага	-Багаар ажиллах чадвартай байх; -Төр, улсын болон байгууллага, иргэдийн нууцыг хадгалах; -Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй байх; -Харилцааны соёлтой байх;	

Сонгон шалгаруулалтыг 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулна.

2. Сонгон шалгаруулалтын бүртгэл:

Сонгон шалгаруулалтад орох иргэний баримт материалыг Үндэсний аудитын газрын 310 тоот өрөөнд 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 09.00-12.00, 14.00-17.00 цагуудад хүлээн авч, бүртгэнэ. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэн дор дурьдсан материалыг бүрдүүлэн **өөрийн биеэр ирж** бүртгүүлнэ. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн анкет (маягт №1);
2. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;
3. Иргэний үнэмлэх;
4. Төрийн албаны мэргэшлийн шалгалт өгсөн материал;
5. Тангарагын хуудас;
6. Ажилласан жилийг тооцох хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эх хувийн хамт;
7. Ажил байдлын тодорхойлолт;
8. 4х3 хэмжээтэй 2 хувь цээж зураг;

Дээрх баримт бичгийг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй.

3. Сонгон шалгаруулалтыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/48 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулна.

4. Сонгон шалгаруулалтад орох иргэдээс дараах шалгалтыг авна.
а/ ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох /60 асуулттай сорилын шалгалт/;

б/ ур чадварын түвшин тогтоох/албан хэрэг хөтлөлт, компьютер/;

в/ ярилцлага хийх;

5. Сонгон шалгаруулалтад төрийн албаны мэргэшлийн шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн иргэд хамрагдана.

6. Сонгон шалгаруулалтад орох иргэдийн уншиж судлах эрх зүйн баримт бичиг

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтын хүрээнд бэлтгэсэн “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын сорилгын хураамж” Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн номын худалдаанд зарагдаж байгаа бөгөөд сонгон шалгаруулалтад орох иргэд дараах жагсаалтад байгаа хууль, журмаас бэлдэнэ үү. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль,
3. Төрийн бэлэг тэмдгийн тухай хууль,
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль,
5. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль,
6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль,
7. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
8. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль,
9. Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль,
10. Төрийн албаны тухай хууль,
11. Төрийн албан ёсны хэлний тухай хууль,
12. Төрийн нууцын тухай хууль,
13. Авлигын эсрэг хууль,
14. Төрийн хяналт шалгалтын тухай хууль,
15. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
16. Хөдөлмөрийн тухай хууль,
17. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль,
18. Байгууллагын нууцын тухай
19. Татварын ерөнхий хууль,
20. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,
21. Нийгмийн даатгалын тухай хууль,
22. Нийгмийн халамжийн тухай хууль,
23. Хувь хүний нууцын тухай
24. Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
25. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль,

26. Шилэн дансны тухай хууль,
27. Архивын тухай хууль,
28. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал,
29. Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого,
30. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль
31. Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай
32. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай
33. Төсвийн тухай хууль
34. Төсвийн тогтвортой байдлын тухай
35. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.
36. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм
37. Соёлын өвийн тухай хууль
38. Соёлын өвийг хамгаалах тухай хууль
39. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
40. Цагдаагийн албаны тухай хууль
41. Эрүүгийн байцаан шийтгэх хууль
42. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
43. Шүүх эрх мэдэл, хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
44. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
45. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
46. Захиргааны ерөнхий хууль /2016.07.01/
47. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2016.07.01/
48. Нийтийн сонсголын тухай хууль
49. Сонгуулийн тухай хууль
50. Төрийн аудитын тухай хууль
51. Захиргааны ерөнхий хууль
52. Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм

**ХАРИЛЦАХ ХАЯГ: ЗАСГИЙН ГАЗРЫН 4 ДҮГЭЭР БАЙР, ӨРӨӨ 310 ТООТ,
УТАС:261585 99061237, 88110661**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ДЭРГЭДЭХ
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН КОМИСС**